

**ХУВИЙН ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ,
АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ХУВЬ ХУНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН
ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2020 оны 10 дугаар
сарын 27-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Б.Баттөмөр, Л.Мөнхбаатар, Б.Саранчимэг нараас 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувийн тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөлд Монгол Улс тэтгэврийн олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэх, ахмад настан олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх, албан журмын болон сайн дурын тэтгэврийн тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоож, хувийн тэтгэврийн санг бий болгох, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулна гэж хууль санаачлагч тусган боловсруулжээ.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэн ирээдүйд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах, хангалттай орлогын эх үүсвэртэй байх боломж бүрдэх, санхүү, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх урт хугацааны сан бий болох, хувийн тэтгэврийн сангүүд бий болсноор санхүүгийн салбар шинээр ажлын байр бий болох чухал ач холбогдолтой гэж үзжээ.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар хувийн тэтгэврийн сангийн эрсдлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Улсын Их Хуралд нийгмийн даатгалын багц хуулийг хэзээ өргөн мэдүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг хувийн тэтгэврийн тогтолцооны талаар салбарын яамны байр суурийг сонсож хууль санаачлагчаас асуулт асууж, хариулт авлаа.

Мөн Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, С.Чинзориг нар тэтгэврийн шинэчлэл хийхийг дэмжиж байгаа бөгөөд хуулийн төслийг засгийн газраас өргөн барих нийгмийн даатгалын багц хуулиудтай уялдуулах шаардлагатай байгаа талаар тус тус саналаа илэрхийллээ.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжих боломжгүй гэж үзсэн тул хуулийн төслийг хууль санаачлагчид


буцаах тухай тогтоолын төсөл боловсруулан чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулахаар тогтсон болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хувийн тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



M.Oyunchimэг

М.ОЮУНЧИМЭГ